



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 68

Хашаат

Сумын тэргүүлэх чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэхь хэсгийн 35.1.17 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тогтоолоор батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3 дах хэсгийн 3.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь.

1. Сумын тэргүүлэх чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Сумын тэргүүлэх чиглэлийг албан байгууллага аж ахуйн нэгж иргэдэд тайлбарлан таниулах, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг сумын Засаг дарга (М.Батсүх), ХААТ-ийн ХЖДҮ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ё.Эрдэнэбулган) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.САНСАРМАА

Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 2022 оны 10 сарын
14 - ний өдрийн 14. тоот тогтоолын хавсралт

**Дэлгэрхангай суманд үйлдвэрлэл,
үйлчилгээ хөгжүүлэх тэргүүлэх чиглэл**

Бизнес эрхлэгчид, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж, шинээр ажлын байр бий болгож, өрхийн орлогыг нэмэгдүүлж, иргэдийн хэрэгцээ, шаардлага хангасан үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоно.

А. Нийтийн аж ахуйн үйлчилгээ

1. Хими цэвэрлэгээний үйлчилгээг бий болгох.
2. Хувцас угаалга, хивс цэвэрлэгээний газартай болох
3. Гар утас, гэр ахуйн цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ
4. Оёдол, эсгүүрийн үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх
5. Үсчин, гоо сайхны салонтой болох
6. Гутал засварын үйлчилгээ
7. Гэрэл зургийн үйлчилгээ

Б. Үйлдвэрлэл, үйлчилгээ

1. Компьютер, графикайн студитэй болох
2. Авто засвар угаалгын төв бий болгох
3. Авто болон дугуй засвар, сэлбэг хэрэгслийн үйлчилгээ
4. Мод. модон эдлэлийн цех байгуулах
5. Гагнуур болон төмөр эдлэлийн үйлчилгээ
6. Тоосго, блок, хавтангийн үйлдвэрлэл байгуулах
7. Таргатын гөлтгөнийн уурхайг түшиглэн гипсэн хавтангийн үйлдвэр байгуулах
8. Зочид буудал зоогийн газар бий болгох
9. Талх, нарийн боовны цех байгуулах
10. Хоол үйлдвэрлэл, цайны газрын үйлчилгээг сайжруулах

В. Хүнс, хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлээр

1. Сүү, сүүн бүтээгдэхүүний цех байгуулах
2. Сүү цагаан идээний өрхийн үйлдвэрлэлийг дэмжих
3. Борц хатаах болон дайвар бүтээгдэхүүн боловсруулах цехтэй болох
4. Мах, махан бүтээгдэхүүний цех байгуулах
5. Ноос, ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх
6. Эсгий, эсгийн үйлдвэрлэл хөгжүүлэх
7. Малын түүхий эд худалдан авах цэгтэй болох
8. Мал нядлах төвлөрсөн цэгийн үйлчилгээ
9. Арьс шир элдэх, боловсруулах цех байгуулах
10. Өлөнгийн анхан шатны боловсруулалт хийх цех байгуулах

11. Мал эмнэлгийн болон үржлийн ажил үйлчилгээ
12. Малын ашиг шимийг нэмэгдүүлэх, сайн үүлдрийн хээлтүүлэгч малаар сайжруулах
13. Мал угаалгын ванн, мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх орчин нөхцлийг сайжруулах
14. Малыг эрүүлжүүлэх вакцинжуулалт тарилга туулгалтанд хамруулах үйлчилгээг сайжруулах
15. Гахай, тахианы туслах аж ахуйг хөгжүүлэх
16. Төмс, хүнсний ногоо тариалалтийг дэмжин хөгжүүлэх
17. Хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх
18. Хүнсний ногоо болон хөмүүл даршлах, савлах цех байгуулах
19. Бэлчээр хашиж, малын тэжээлийн ургамал тариалах

Г. Бусад үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:

1. Сумын төвд хог ангилан ялгах, дахин боловсруулах шинэлэг технологи нэвтрүүлэх
2. Түүх соёл, байгалын үзэсгэлэнт газруудаа олон нийтэд сурталчлан аялалын маршрут бий болгох үйлчилгээ
3. Орон нутаг судлах танхим, музейн үзмэр үйлчилгээг бий болгох /ногоон дээвэрт/
4. Спорт тоглоомын үйлчилгээ
5. Ахмадын амралт, сувилалын газартай болох
6. Жуулчдад зориулсан бэлэг дурсгалын үйлдвэрлэл эрхлэх